

BOARD AUDIT COMMITTEE MEETING 21st September 2021

The quarterly meeting of this Committee was held on September 21st, 2021, by video conferencing under my chairmanship.

1. The Committee had already approved the Minutes of the last meeting by circulation.

A list of follow-up actions on matters arising from the minutes was included in the meeting document pack. There was no question regarding this item.

2. At the invitation of the Committee, representatives from the external audit firm EY were admitted to the meeting. Mr. Cu, the partner in charge of the audit of the Xacbank, presented EY findings from the review of the prior year's financial statements. They have proposed some adjustments to certain figures which were accepted by the management. Management did not agree to some requested adjustments due to the difference in accounting treatment method of the central bank and FASB.

The Committee approved the management decision regarding the adjusted and non-unadjusted items.

All the independent directors who are members of this Committee voted independently and freely on this matter.

3. The Committee acknowledged the presentation of the reports of the Internal Audit on the audit work completed during the previous quarter.
4. The Committee reviewed the report of "Related Parties" to be submitted to the central bank. As there was information, it was proposed that those parties who do not disclose the requested information mention the reasons, legal and privacy laws, or others, for the sake of completeness.
5. There was no matter of conflict of interest that was raised not came to the attention of the Committee.

Prepared and submitted by



Lim Sit Chen Lam Pak Ng (Maurice Lam)

Dated 29th September 2021.

ТУЗ-ийн Аудитын Хорооны 2021 оны 9-р сарын 21-ний өдрийн хурлын тайлан

Хорооны улирлын ээлжит хурлыг 2021 оны 9-р сарын 21-ний өдөр видео холбооны хэрэгслээр дамжуулан хуралдуулж, хурлыг даргалав.

1. Хорооны өмнөх хурлын тэмдэглэлийн төслийг имейлээр дамжуулан хэлэлцэж, хурлын тэмдэглэлийг эцэслэн баталсан тухай тэмдэглэв.

Өмнөх хурлаас гаргасан шийдвэр, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний жагсаалтыг хурлын материалуудад оруулж, Хорооны гишүүдэд танилцуулсан ба гишүүдээс энэ талаар аливаа асуулт, тодруулах зүйл асуугаагүй болно.

2. Хорооны урилгаар хөндлөнгийн хяналтын Эрнст Энд Янг компанийн төлөөлөгчид хуралд оролцож, ХасБанкны аудитыг хариуцаж буй захирал Чү ХясБанкны өмнөх жилийн санхүүгийн тайланг хянаж, гаргасан дүгнэлтийг танилцуулав. Хөндлөнгийн хяналтаар зарим тоонд залруулга хийгдсэн бөгөөд эдгээр залруулгыг гүйцэтгэх удирдлага хүлээн зөвшөөрсөн. Олон улсын санхүү, нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Монголбанкны шаардлагын хоорондох зөрүүгээс үүдэлтэй зарим залруулгыг гүйцэтгэх удирдлага хүлээн зөвшөөрөөгүй болно.

Гүйцэтгэх удирдлагаас залруулга хийх, хийхгүй эсэх талаар гаргасан шийдвэрийг Хорооноос дэмжиж баталсан. Хорооны бүрэлдэхүүнд ажиллаж буй хараат бус гишүүд энэ асуудлаар бие даасан саналаа чөлөөтэй өгсөн болно.

3. Хорооны хурлаар ДАГ-аас өмнөх улиралд хийж гүйцэтгэсэн аудитын ажлын тайланг хэлэлцэж тэмдэглэв.
4. Хорооны хурлаар МБ-нд хүргүүлэх Холбогдох этгээдийн мэдээллийн санг хэлэлцэж нягтлав. Мэдээллийн санг бүрэн гүйцэд болохын тулд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөөгүй этгээдүүд мэдээлэл өгөхгүй байгаа шалтгаан, нууцын тухай хууль болон бусад хуулийн заалт, эсвэл бусад шалтгааныг мэдэгдэж тайлбар өгөх нь зүйтэй гэж Хорооноос завлөв.
5. Хорооны хурлаар сонирхлын зөрчилтэй аливаа асуудлыг хэлэлцээгүй, Хорооны гишүүдийн анхааралд ийм асуудлыг мэдэгдээгүй болно.

Бэлтгэж танилцуулсан:

Лим Сит Чен Лам Пак Нг (Морис Лам)
2021 оны 9-р сарын 29-ний өдөр

BOARD RISK MANAGEMENT COMMITTEE MEETING 21st September 2021

As an independent member of the Board and a member of the Risk Management Committee I attended the meeting held on September 21st, 2021.

The Committee reviewed the Bank Risk report, noting that the risk metrics were all within the approved parameters and the bank's liquidity and capital positions were strong.

Following a review of the Risk Appetite, made at the request of the Risk Committee, the Committee recommended for Board approval a series of changes to the Risk Appetite parameters.

The Committee discussed the Liquidity and Interest Rate Risk Analysis made by management as well as the ECL methodology improvement by EY, the external auditors and recommended the Board to take the appropriate actions.

The Committee discussed an agenda item which was added by the Chairperson of the Committee and approved by the Committee.

According to the Chairman, the Bank needs to be cognizant of a potential reputational risk regarding the level of compensation of board members when this information will be disclosed once the Bank's shares are listed on the Stock Exchange of Mongolia. There was a discussion on this potential risk and how the Bank could mitigate this risk like being prepared to explain the reasons for the level fees paid to members of the board. It was agreed that this matter will be brought up to the attention of the Board.

I supported all the recommendations to Board.

There was no item on the agenda nor during the deliberations of the Committee where there could have been a conflict of interest.

Prepared by



Lim Sit Chen Lam Pak Ng (Maurice Lam)
29th September 2021

ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны 2021 оны 9-р сарын 21-ний өдрийн хурлын тайлан

ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Эрсдэлийн Удирдлагын Хорооны гишүүний хувьд тус Хорооны 2021 оны 9-р сарын 21-ний өдөр хуралдсан Хорооны улирлын ээлжит хуралд оролцсон.

Хорооны хурлаар Банкны эрсдэлийн тайланг хэлэлцэж, эрсдэлийн үзүүлэлтүүд бүгд батлагдсан хязгаарт байгаа бөгөөд Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон хөрөнгийн харьцаа өндөр түвшинд байгааг тэмдэглэв.

Хорооны хүсэлтийн дагуу хурлаар Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хянан үзэж, Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнд оруулах хэд хэдэн өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар батлуулах зөвлөмж гаргав.

Мөн Хорооны хурлаар Банкны төлбөр гүйцэтгэх чадвар, Хүүгийн хувийн эрсдэлийн дүн шинжилгээ, мөн Эрнст Энд Янг хөндлөнгийн аудитораас гаргасан зөвлөмжийн дагуу Зээлийн болзошгүй алдагдлыг тооцох аргачлалыг сайжруулах талаар хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авах талаар ТУЗ-д зөвлөмж гаргав.

Үүнээс гадна Хорооны даргын санал болгож, Хорооны гишүүдийн баталсны дагуу дараах асуудлыг хэлэлцэв.

Банкны хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалахад ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын мэдээлэл ил тод болж, үүнтэй холбоотой Банкны нэр хүндийн эрсдэл гарч болзошгүйг Банкнаас анхаарах нь зүйтэй гэж Хорооны дарга тэмдэглэв. Хорооны хурлаар болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн бууруулах, ТУЗ-ийн гишүүдэд олгож буй цалин урамшууллын хэмжээ, шалтгааныг тайлбарлахад бэлэн байх талаар хэлэлцэв. Энэ асуудлыг ТУЗ-ийн анхааралд хүргэх нь зүйтэй гэж Хорооны гишүүд тохиролцож дүгнэв.

Миний зүгээс ТУЗ-д оруулах бүх зөвлөмжүүдийг дэмжсэн.

Хорооны хурлаар хэлэлцэх асуудал дотор, мөн хэлэлцүүлгийн явцад сонирхлын зөрчилтэй аливаа асуудал гараагүй болно.

Тайланг бэлтгэсэн:

Лим Сит Чен Лам Пак Нг (Морис Лам)
2021 оны 9-р сарын 29-ний өдөр

BOARD MEETING 22nd September 2021

As an independent member, I attended the quarterly Board meeting held on 22nd September, 2021 by video conferencing.

The Board papers were circulated sufficiently ahead of time and had enough time to study the documents and draw my own conclusions on matters requiring a decision.

The Board went over the agenda items and after reports by the chairpersons of each board committee approved the recommendations of these various board committees.

Regarding the potential reputation risk regarding the level of directors' remuneration, the Board decided to request the Governance Committee to look into this and make appropriate recommendations to mitigate this risk.

Management presented an update on the IPO project. The merger of XacLeasing and XacBank is proceeding according to plan.

The Board reviewed and discussed the economic and banking update presented by management.

Management presented a review of the bank's performance overall and by each business line as well as the status of the progress of the Bank's initiative to upgrade its technology and digital bank platform. There ensued a healthy exchanged of opinions and suggestions were made by members of the board to assist management in the monitoring and reporting of the bank's performance.

As an independent member I was able to vote freely on all the resolutions.

There was no item that could have given rise to a conflict of interest for any member of the board. Members were encouraged and allowed to participate and express opinions freely.

Prepared by



Lim Sit Chen Lam Pak Ng (Maurice Lam)
29th September, 2021

ТУЗ-ИЙН 2021 ОНЫ 9-Р САРЫН 22-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ТАЙЛАН

2021 оны 9-р сарын 22-ны өдөр видео холбооны хэрэгслээр дамжуулан хуралдсан ТУЗ-ийн улирлын ээлжит хуралд оролцсон.

ТУЗ-ийн хурлын материалуудыг хурлаас өмнө тарааж, хурлаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилан судалж, ТУЗ-өөс гарах шийдвэрүүдийн талаар өөрийн байр суурийг тодорхойлоход хангалттай цаг хугацаа олгосон.

ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн хороодын дарга нар хороодын тайланг танилцуулж, ТУЗ-ийн хороодоос гаргасан зөвлөмжүүдийг хэлэлцэж баталсан.

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээтэй холбоотойгоор гарч болзошгүй нэр хүндийн эрсдэлийн хувьд ТУЗ-ийн гишүүд энэ асуудлыг ТУЗ-ийн Засаглалын хороогоор судлуулж, энэ эрсдэлийг бууруулах талаар зөвлөмж гаргах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрэв.

Банкны хувьцааг нийтэд санал болгох төслийн талаар гүйцэтгэх удирдлагаас мэдээлэв. ХасБанк, ХасЛизинг компаниудыг нэгтгэх ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгааг мөн мэдээлэв.

Эдийн засаг, банкны салбарын талаарх тайлан мэдээлийг мөн хэлэлцэв.

Банкны гүйцэтгэх удирдлагаас Банкны үйл ажиллагаа, нийт гүйцэтгэл болон бизнесийн чиглэл бүрийн гүйцэтгэлийн талаар тайлагнаж, мөн Банкны үндсэн систем, цахим банкны системийг шинэчлэх төсөл, санаачлага, явцын талаар танилцуулав. ТУЗ-ийн гишүүд Банкны үйл ажиллагааг хянах, гүйцэтгэх удирдлагад тусалж зөвлөх үүднээс үзэл бодлоо солилцож, санал гаргаж, үр дүнтэй хэлэлцүүлэг явуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд ТУЗ-ийн шийдвэрүүд дээр чөлөөтэй санал бодлоо илэрхийлж санал өгөв.

Хурлын үеэр сонирхлын зөрчилтэй асуудал гарагүй болно. ТУЗ-ийн гишүүд саналаа чөлөөтэй илэрхийлж, хуралд оролцов.

Тайланг бэлтгэсэн:

Лим Сит Чен Лам Пак Нг (Морис Лам)
2021 оны 9-р сарын 29-ний өдөр